

ЗАХ ЗЭЭЛ ҮҮСГЭГЧТЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

20... оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК (цаашид “Бирж” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Батбилэг, нөгөө талаас “..... ҮЦК” ХХК (цаашид “Зах зээл үүсгэгч” гэх), түүнийг төлөөлж, Гүйцэтгэх захирал нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлийг харилцан тохиролцож ... сарын хугацаатай байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Бирж нь “Арилжааны журам”-д заасан шалгуур, шаардлага хангасан гишүүн үнэт цаасны компанид зах зээл үүсгэгчээр ажиллах зөвшөөрөл олгож, зах зээл үүсгэх үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.2. Талуудын хооронд үүсэх энэхүү гэрээгээр зохицуулаагүй харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “Хороо” гэх), Биржээс баталсан журам, заавраар зохицуулна.
- 1.3. Гэрээ нь талууд харилцан гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, аль нэг талын санаачилгаар дуусгавар болно.
- 1.4. Холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд, эсхүл талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.
- 1.5. Талууд гэрээний дараах үндсэн нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна. Үүнд:
 - 1.5.1. Зах зээл үүсгэх үнэт цаас:
 - 1.5.2. Зах зээл үүсгэх хугацаа:
 - 1.5.3. Зах зээл үүсгэгчийн худалдаж авах болон худалдах захиалгын үнийн зөрүүний зөвшөөрөгдсөн дээд хэмжээ:
 - 1.5.4. Тухайн арилжааны өдөр зах зээл үүсгэх хугацаа:

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

- 2.1 Бирж дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 2.1.1 Зах зээл үүсгэгчийн хууль, дүрэм журам, гэрээгээр хүлээсэн үүрэг болон Биржээс гаргасан шийдвэрийг биелүүлэхийг шаардах;
 - 2.1.2 Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх;
 - 2.1.3 Зах зээл үүсгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд

гэрээний 3.2-т заасан арга хэмжээг авах;

2.2 Бирж дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

2.2.1 Энэ журмын шаардлага хангасан гишүүн үнэт цаасны компанийг зах зээл үүсгэгчээр сонгон гэрээ байгуулах;

2.2.2 Гэрээний дагуу зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих;

2.2.3 Холбогдох журамд заасны дагуу зах зээл үүсгэгчид хөнгөлөлт урамшуулал олгох;

2.3 Гишүүн нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

2.3.1 Журмын 6.18 дах заалтын дагуу зах зээл үүсгэгчээр ажиллах тохиолдолд тухайн үнэт цаасны арилжааны шимтгэлийг 20-50 хүртэлх хувиар хөнгөлүүлэх эрхтэй;

2.4 Гишүүн нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

2.4.1 Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа нь харилцагчтай сонирхлын зөрчил үүсгэх тохиолдолд энэ талаар харилцагчид урьдчилан мэдэгдэх;

2.4.2 Зах зээл үүсгэх арилжааны аргыг ашиглан гэрээнд заасан нөхцлийн дагуу зах зээл үүсгэх;

2.4.3 Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг бусад захиалгын баримт материалаас тусгаарлаж, зохих бүртгэлийг хөтөлж, гурваас доошгүй жилийн хугацаанд хадгалах;

ГУРАВ. ХАРИУЦЛАГА

3.1 Биржийн хяналт шалгалт хариуцсан нэгж энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд Хяналт шалгалтын журамд заасан үндэслэл, чиглэлийн дагуу зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд зайн болон газар дээрх хяналт, шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулна.

3.2 Зах зээл үүсгэгч нь энэхүү журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд дараах арга хэмжээг авна. Үүнд:

3.2.1 Сануулах;

3.2.2 Үзүүлсэн шимтгэлийн хөнгөлөлт, урамшууллыг хэсэгчлэн болон бүтнээр нь буцаан төлүүлэх;

3.2.3 Гэрээг цуцлах;

3.2.4 Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах;

3.2.5 Гишүүнчлэлийн эрхийг түдгэлзүүлэх;

3.2.6 Гишүүнчлэлийн эрхийг цуцлах;

ДӨРӨВ. БУСАД

4.1 Бирж нь зах зээл үүсгэгчдийн жагсаалт, түүнд орсон өөрчлөлтийн талаар цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

4.2 Гэрээг аль нэг тал нь дангаараа өөрчлөх эрхгүй ба талууд харилцан

- тохиролцсоны үндсэн дээр бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 4.3 Энэхүү гэрээгээр тохиролцоогүй бусад асуудлыг Монгол Улсын Иргэний хууль, болон бусад хууль тогтоомжид зааснаар зохицуулна.
- 4.4 Гэрээний асуудлаар маргаан үүссэн тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Тохиролцоонд эс хүрвэл асуудлыг Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 4.5 Энэхүү гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЧИНГИС ХААН ХӨРӨНГИЙН БИРЖИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

ЗАХ ЗЭЭЛ ҮҮСГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

.....

.....

Утас:
Хаяг:

Утас:
Хаяг: